

ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН ҮЗЭЛ, БАРИМТЛАЛЫГ БАГШ МЭРГЭЖЛИЙН ЗАРИМ ХӨТӨЛБӨРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

/Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн жишээн дээр/

Авшукир Авзал

Баян-Өлгий аймаг, Өлгий сум,

abzal7889@gmail.com

Хураангуй

Дэлхийн улс орнуудын боловсролын системд хэрэглэж буй суралцахуйн үр дүнг чухалчилсан хандлага бүхий “Үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ)”-ын тогтолцоог манай оронд “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд нэвтрүүлэх ажил үе шаттайгаар эрчимтэй хэрэгжиж, дүгнэх шатандаа явж байна.

Энэхүү өгүүлэлд Монгол орны баруун хязгаарт 30 гаруй жил багшлах боловсон бэлтгэж ирсэн Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуульд ҮДСБ-ын үзэл, баримтлалыг нэвтрүүлж буй байдал, үр дүнгийн талаар өгүүлэх болно.

Тус сургуулийн эрдэмтэн багш нар ҮДСБ-ын тогтолцооны онол, арга зүйн сургалт семинарт удаа дараа хамрагдаж, хамт олны дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан билээ. Багш нарын хэлэлцүүлгээр тус сургуулийн багш, бага ангийн боловсрол (ББАБ) болон багш, сургуулийн өмнөх насны боловсрол (БСӨНБ) хөтөлбөрүүдийг ҮДСБ-ын үзэл баримтлалаар шинэчилэх, турших тухай нэгдсэн ойлголтод хүрч, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тоймлон оруулав.

Салбар сургуулийн хөтөлбөрийн хороо ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, нийт багш нартай хамтран ажиллаж байна.

Түлхүүр үг: Үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ), CDIO, Багш, бага ангийн боловсрол (ББАБ), Багш, сургуулийн өмнөх насны боловсрол (БСӨНБ)

Оршил

ҮДСБ-ын тогтолцоо нь урьдчилан төсөөлсөн суралцахуйн үр дүнг үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлсний дараа бодит хүрсэн үр дүнд үнэлгээ хийх замаар төсөөлсөн суралцахуйн үр дүнгээ эргэж сайжруулдаг эргэх холбоо бүхий тасралтгүй ажиллагаатай систем болохын хувьд энэхүү үзэл, баримтлалыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд сургууль бүрийн эрдэмтэн багш, судлаачид, оюутнуудын оролцоо чухал билээ.

ҮДСБ-ын үзэл баримтлалыг БАББ, БСӨНБ хөтөлбөрүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор энэхүү тойм өгүүллийг уншигчдад хүргэж байна.

2018-2019 оны хичээлийн жилийн 2-р улирлаас эхлэн сургуулийн сургалтын үйл ажиллагаандаа ҮДСБ-ын стандарт, арга зүйг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, тодруулбал, БАББ болон БСӨНБ

хөтөлбөрүүдийг ҮДСБ-ын үзэл баримтлалаар шинэчлэн боловсруулах ажлуудыг тодорхой төлөвлөгөөний дагуу эрчимтэй хэрэгжүүлсэн билээ.

2019-2020 оны хичээлийн жилд ҮДСБ-ийн үзэл баримтлалын дагуу хийгдсэн хөтөлбөрүүдийг турших ажил явагдсан болно.

Энэхүү өгүүлэлд бид ҮДСБ-ын үзэл баримтлалыг БАББ, БСӨНБ хөтөлбөрүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалал, гарсан үр дүн, шийдвэрийн тухай өгүүлэх болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Тус сургуульд ҮДСБ-ийн үзэл, баримтлалыг багш мэргэжлийн зарих хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх зорилтын хүрээнд сургуулийн удирдлага болон мэргэжлийн тэнхим, профессор багш нарын санал, санаачлагаар хийгдсэн ажлуудыг тоймлон хүргэж байна.

1. ҮДСБ-ийн үзэл, баримтлалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил

Аливаа шинэ санааг хэрэгжүүлэхэд тухайн хувь хүн болоод байгууллагаас тодорхой хэмжээний бэлтгэл ажил шаарддаг билээ. Ийнхүү ҮДСБ-ын үзэл, баримтлалыг хэрэгжүүлэхэд манай сургууль дараах бэлтгэлийг хангасан болно. Үүнд:

А.Сургалтын материаллаг орчин бүрдүүлсэн байдал.

Орчин үеийн дэвшилтэт технологт үндэслэн багшийн хөдөлмөрийн үр дүн болон оюутнуудын сурах хүсэл, тэмүүлэлийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч Дээд боловсролын шинэчлэлийн төслийн (ДБШТ) дэмжлэгтэйгээр БАББ хөтөлбөрийн гол цөм болсон бага боловсролын монгол хэл, дидактик болон бага боловсролын математикийн онол, дидактик хичээлүүдийн бүрэн хэмжээний сургалтын хэрэглэгдхүүн, ном, сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл бүхий 45 000 000 төгрөгийн санхүүжилт авч, хоёр кабинетийг бүрэн тохижуулан сургалтад ашиглаж байна. Энэ нь бидэнд ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний дэмжлэг болсон билээ.

Б. ДБШТ-ийн хүрээнд хэрэгжүүлсэн багц сургалтуудад профессор багш нарыг хамруулсан байдал.

Профессор багш нарт ҮДСБ-ын онол, үзэл баримтлалын талаар мэдлэг олгох зорилтын

хүрээнд ДБШТ-ээс хэрэгжүүлсэн сургалт, семинарт багш нарын багыг тогтмол оролцуулж байв. ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйг инжэнэрчлэлийн боловсрол олгох хөтөлбөрт хэрэгжүүлсэн ШУТИС-ийн багш нарын болон ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуулиудын туршлагыг судлах, улмаар багш мэргэжлийн хөтөлбөрт хөрвүүлэн хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж, нийт багш нарыг 2018-2019 оны хичээлийн жилийн өвлийн амралтаар Улаанбаатар хотод долоо хоногийн сургалт семинарт хамруулсан нь үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.

Мөн ШУТИС-ийн “CDIO-ийн мастер багш” нарыг сургуульдаа урьж, ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйг хэрэгжүүлэхэд багш нарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийн талаар хамтран ажиллаж, сургалт, хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулав.

Ийнхүү багшлах боловсон хүчнийг чадавхжуулах бэлтгэл ажлын хүрээнд ДБШТ-өөс хэрэгжүүлсэн багц сургалтад профессорын багийг 4 удаа хамруулав.

Багшлах бүрэлдэхүүний сургалт, семинарт хамрагдсан байдлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

Багш нарын ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйн багц сургалтад хамрагдсан байдал

Д/д	Нийт багшийн тоо	CDIO-ийн арга зүйн сургалтад хамрагдсан багш нарын тоо	CDIO-ийн арга зүйн сургалтад хамрагдсан хугацаа, өдөр	CDIO-ийн арга зүйн хэд дэх багц сургалтад хамрагдсан байдал			
				CDIO-ийн үзэл баримтлал, стандарт	Харилцан уялдаатай хичээлүүд бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулах	Шинэ бүтээгдэхүүн болон системийг сэтгэж, зохион бүтээх	Идэвхитэй сургалтын арга зүй
1	23	19	2018.05.10-11 2019.01.23-24	19	19	9	8

Хүснэгтээс харахад профессор багш нарын 82,6 хувь нь ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйн багц сургалтад хамрагдсан нь бидний бэлтгэл ажил хангагдсан гэж үзэхээр болж байна.

2. ҮДСБ-ын үзэл баримтлалаар Багш, бага ангийн боловсрол болон багш, сургуулийн өмнөх насны боловсрол хөтөлбөрүүдийг шинэчилсэн нь

ҮДСБ-ын үзэл баримтлалыг сургуульд хэрэгжүүлэхэд сургалтын албанаас “Сургалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан боловсролын тогтолцооны үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх, сайжруулах үйл ажиллагааг удирдлагаар хангах” зорилгын хүрээнд дараах алхамуудыг тодорхойлж, ажлын төлөвлөгөө гарган ажиллав. Үүнд:

Алхам 1. Сургуулийн эрхэм зорилго, алсын харааг тодорхойлох

Алхам 2. Мэргэжлийн тэнхмүүдийн эрхэм зорилгыг тодорхойлох

Алхам 3. Багш, бага ангийн боловсрол, багш, сургуулийн өмнөх насны боловсрол мэргэжлийн хөтөлбөрүүдийн зорилго, зорилтыг тодорхойлох

Алхам 4. Хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүнг CDIO мэдлэг, ур чадварын жагсаалтын дагуу боловсруулах /PLO/

Алхам 5. Хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүн /PLO/-г, хичээлийн суралцахуйн үр дүн /CLO/-той холбох

Алхам 6. Багш нар заадаг хичээл тус бүрээр хөтөлбөрийн суралцахуйн үр дүн /PLO/-г, тухайн хичээлийн суралцахуйн үр дүн /PLO/-той харилцан уялдаа бүхий хөтөлбөр боловсруулах

Алхам 7. Багш нарын боловсруулсан хөтөлбөрүүдийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах

Алхам 8. Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрүүдээр сургалт явуулах, үнэлгээ, дүгнэлт хийх

Ийнхүү алхамуудыг хэрэгжүүлэхийн тулд нийт багш нарын дунд 5 удаа хэлэлцүүлэг явуулж, хамтран ажилласны дүнд дараах үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

Сургуулийн эрхэм зорилго, алсын харааг ҮДСБ-ын үзэл баримтлалд нийцүүлэн шинэчилж, үүнтэй уялдуулан Боловсрол судлал, арга зүйн тэнхим, тухайн тэнхимд хэрэгжүүлж буй буй ББАБ, БСӨНБ мэргэжлийн хөтөлбөрүүдийн зорилгыг боловсруулав.

СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Үр дүнд суурилсан боловсролын шаардлага, бүс нутгийн онцлог, эрэлт хэрэгцээг хангахуйц хөгжих чадамжтай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Сургуулийн алсын хараа

Бүс нутгийн тогтвортой хөгжлийг тодорхойлогч сургалт, судалгааны тэргүүлэгч их сургууль болох

Боловсрол судлал арга зүйн тэнхимийн зорилго: Мэргэжлийн онол, арга зүйн чадвартай судлаач багш бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилго: Хөтөлбөр нь суралцагчдад олон улсын дээд боловсролын стандартад нийцсэн мэдлэг эзэмшүүлэх, тасралтгүй хөгжих хандлага бүхий мэргэжилтэн болж төлөвших цогц үйлчилгээ үзүүлнэ.

Багш, бага ангийн боловсрол хөтөлбөрийн зорилго: Сургалтын онол, арга зүйг эзэмшсэн, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц, хос хэлний чадамжтай бага боловсролын багш бэлтгэхэд оршино.

Багш, сургуулийн өмнөх насны боловсрол хөтөлбөрийн зорилго: Бага насны хүүхэдтэй ажиллах арга барилтай, хүүхдэд ээлтэй, хос хэлний мэдлэг чадвар бүхий багш бэлтгэхэд оршино.

2. Багш, бага ангийн боловсрол болон багш, сургуулийн өмнөх насны боловсрол мэргэжлийн хөтөлбөрүүдээр элсэн суралцагчид суралцах хугацаандаа эзэмших мэдлэг, чадвар, хандлага буюу CDIO мэдлэг ур, чадварын жагсаалтыг нарийвчлан боловсруулав. Энэ нь:

1. Хувь хүний чадвар, хандлага
2. Хүмүүстэй харилцах, багаар ажиллах болон харилцааны чадвар
3. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар
4. Нийгэм, соёлын чадвар
5. Төрийн хэлний чадвар олгох гэсэн 5 багц хэсгээс бүрдэж байгаа ба тус бүрийн дэд чадварыг мэргэжлийн онцлогтой уялдуулж тодорхойлж өгсөн болно. Ийнхүү 5 багц чадварын хүрээнд 34 дэд чадварыг тодорхойлов.

Мөн энэхүү тодорхойлсон CDIO мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт болон ажил олгогчид, төгсөгчид, багш нарын саналыг харгалзан хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тус хөтөлбөрийн зорилго, зорилтыг хангахуйц байдлаар боловсруулав.

3. Хөтөлбөрийн CDIO мэдлэг, ур чадвар, хандлага, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг сургалтын хөтөлбөрт заагдсан хичээл бүрт холбох, заах, төлөвшүүлэх, үнэлэх тухай тусгах, тэдний уялдаа холбоох гаргах талаар мэргэжлийн багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-ийн хамаарлын матрицыг тодорхойлов. Ингэснээр багш бүр заадаг хичээлийн хөтөлбөрийг CDIO мэдлэг, ур чадвар, хандлагын хүрээнд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд нийцүүлэн боловсруулах боломж нээгдсэн билээ.

Ийнхүү хөтөлбөрийн CDIO мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-г тогтоосноор тухайн хөтөлбөрөөр суралцсан төгсөгчийн ирээдүйн зураглалыг гаргаж чадсан билээ.

4. Хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулан боловсруулсан багш нарын хөтөлбөрүүдийг сургалтын төлөвлөгөөний блок тус бүрээр хэлэлцүүлж, нэгдсэн нэгэн ойлголтод хүрснээр багш бүр өөрийн заах арга барил, туршлагад тулгуурлан боловсруулсан хөтөлбөрөө туршин хэрэгжүүлэхэд бэлэн болсон билээ.

5. 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн “ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйгээр боловсруулсан хөтөлбөрүүдийг туршин хэрэгжүүлэх” тухай салбар сургуулийн захирлын 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/16 тоот тушаал гарч хэрэгжиж байна.

Ийнхүү сургалтын алба, мэргэжлийн тэнхимээс бүрдүүлсэн зөвлөх баг багш нарын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах зорилгоор хичээлд сууж анализ хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлуудыг тогтоосон графикайн дагуу тасралтгүй хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Салбар сургуульд ҮДСБ-ын CDIO стандарт, арга зүйг нэвтрүүлэх төлөвлөгөөт ажлуудыг дэд дараатай хэрэгжүүлсний үр дүнд дараах бодит үр дүнд хүрсэн билээ. Үүнд:

1. Орчин үеийн техник, технологиор тоноглогдсон, иж бүрэн хичээлийн хэрэглэгдхүүнээр хангагдсан хоёр кабинетийг шинээр байгуулав.

2. ББАБ, БСӨНБ мэргэжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болох хөтөлбөрийн танилцуулгыг ҮДСБ-ын үзэл баримтлалд нийцүүлэн шинээр боловсруулав. Энэхүү бичиг баримтад хөтөлбөрийн зорилго, зорилт, хичээлээр олгох CDIO мэдлэг, ур чадварын жагсаалт, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, төгсөгчийн загвар, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-гийн харилцан хамаарал, сургалтын төлөвлөгөөний дагуу бүх хичээлийн хөтөлбөрүүд, оюутны үнэлгээ зэрэг нь багтсан болно.

3. Бидний боловсруулсан хөтөлбөр нь ҮДСБ-ын шаардлага, суралцагчдын хүсэл сонирхол, эрэл хэрэгцээг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор тус хөтөлбөрт 2019-2020 оны хичээлийн жилд элсэн суралцагчдын хувьд дөрвөн жилийн хугацаагаар туршилтын журмаар хэрэгжүүлэхээр болов. Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх, тасралтгүй сайжруулахад түлхэц болно хэмээн бид үзэж байна.

Эцэст нь дүгнэхэд ҮДСБ-ын үзэл санааг амьдралд бодитоор хэрэгжүүлэх, үр дүнг үзэх нь оновчтой төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах, байнга үнэлэлт дүгнэлт хийж, тасралтгүй сайжруулах эргэх холбоо бүхий процесс байх учиртай юм.

Ашигласан материал:

1. “Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж” БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, УБ., 2017 он.
2. “Сургалтын албаны 2018-2019 оны хичээлийн жилийн 1-р улирлын үйл ажиллагааны тайлан” Өлгий, 2018, ху.16
3. “CDIO стандарт арга зүйн сургалт” (Багц сургалт 1) БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, УБ., 2017 он.
4. “CDIO стандарт арга зүйн сургалт” (Багц сургалт 1) БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, УБ., 2017 он.
5. “Харилцан уялдаатай хичээлүүд бүхий нийлмэл сургалтын төлөвлөгөө боловсруулах нь” БСШУСЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, УБ., 2018 он
6. Эрдэнэхүү Н, Нямсүрэн П ба бусад. Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөмж. УБ., 2017 он.